



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Г

Г

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 112 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн тархи, зүрхний судсан дотуурх оношилгоо эмчилгээ хийх ангиографи аппаратын рентген хоолойг шинээр худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд шаардагдах 453.800.000 /Дөрвөн зуун тавин гурван сая найман зуун мянган/ төгрөгийн гэрээ байгуулах, гэрээ сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга /Ц.Төмөр-Очир/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэлийг хуулийн дагуу хангуюлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080305